



МОНГОЛ УЛС  
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2019 оны 11 сарын 26 өдөр

Дугаар A/770

Ховд

Г Жуух бичгээр шагнах тухай Г

Аймаг, нийслэлийн Засаг даргаас олгох шагналын тухай Засгийн газрын 1997 оны 54 дүгээр тогтоолын 1-ийн "Е", аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2017 оны 28 дугаар тогтоолоор батлагдсан "Аймгийн шагналын журам"-ын 1.2.8, 3.3.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Дархан хилийнхээ халдашгүй байдлыг сахин хамгаалах, ард иргэдийнхээ амгалан тайван амьдрах нөхцөл бурдүүлэх үйл хэрэгт өөрийн хүч хөдөлмөр, сэтгэл зүтгэлээ дайчлан хамт олноо манлайлан олон жил үр бүтээлтэй ажиллаж буй Хилийн 0130 дугаар ангийн Хилийн боомтын аюулгүй байдал, шалган нэвтрүүлэх алба эрхэлсэн орлогч, хошууч Ш.Түмэнжаргал, Харуулын дарга, ахлах ахлагч Д.Энхтайван нарыг аймгийн Засаг даргын "Жуух бичиг"-ээр шагнасугай.

2. Аймгийн Засаг даргын Жуух бичгээр шагнагдсан Ш.Түмэнжаргал, Д.Энхтайван нарт 1 сарын хугацаанд үндсэн цалингийн 20 хувиар тооцож урамшуулал олгохыг Хилийн 0130 дугаар ангийн захирагч, хурандаа /О.Азхүү/-д зөвлөсүгэй.

ЗАСАГ ДАРГА

Б.ДҮГЭРЖАВ



02 03765  
D/Zax-A/770-Da